



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
КОМПАНИУДАД

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Нам Ян Жугийн гудамж 32/1,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13335
Утас: 45 39 94, Факс: (976-11) 45 86 99,
Цахим шуудан: info@nccd.gov.mn,
Цахим хуудас: www.nccd.gov.mn

2026.04.27 № 3-3/572

танай _____-ны № _____-т

Үнийн санал авах тухай

Тус төв нь Глобал сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй ДОХ, Сүрьеэгийн төслийн санхүүжилтээр Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн системд нэвтрэх үеийн мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор имэйл болон утсаар OTP илгээх, нууц үгийн бодлогыг сайжруулах, хэрэглэгчийн эрхийн удирдлага, баталгаажуулах код илгээх API, сессийн хяналт, аюулгүй байдлын penetration test, хэрэглэгчийн тохиргооны UI болон имэйл илгээх SMTP тохиргоо зэрэг шинээр хөгжүүлэлтийн ажлуудыг хийж гүйцэтгэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналд дараах мэдээллийг тусгана уу:

1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2. Нийлүүлэх хугацаа /2026.6.10 дууссан байх/
3. Үнийн саналын албан бичиг
4. Хөгжүүлэгчийн хийсэн ажлуудыг тусгаж өгнө. Сүрьеэгийн цахим систем, болон апп хөгжүүлж байсан доод тал нь 2 жилийн туршлагатай.

Үнийн санал ирүүлэх хугацаа нь 2026 оны 04 дугаар сарын 24-ний өдрийн 16 цаг 30 минут хүртэл байна. Үнийн саналыг tender@nccd.gov.mn хаягаар и-мэйлээр ирүүлнэ үү. Дэлгэрэнгүй мэдээллийг 72224244 дугаараас лавлана уу.

ЗАХИРАЛ



С. ЭНХБОЛД

Халдварт өвчин судлалын үндэсний
төвийн ерөнхий захирлын 2026 оны
7-3/572 дугаартай албан бичгийн хавсралт

9924040027
7101 FCT7672

СҮРЬЕЭГИЙН ЦАХИМ БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ (TUBIS) БОЛОН TUB
АППЛИКЕЙШНИЙ НЭВТРЭЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
САЙЖРУУЛАХ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛ

№	Ажлын төрөл	Агуулга / Хийх ажил
1	Имэйл болон утсаар OTP (One-Time Password) илгээх систем	Хэрэглэгч нэвтрэхдээ нууц үгээ оруулсны дараа бүртгэлтэй имэйл эсвэл утсаар нэг удаагийн баталгаажуулах код илгээдэг 2FA систем нэвтрүүлэх. Firebase, SMTP, Twilio/SMS Gateway ашиглана.
2	Нууц үгийн бодлого сайжруулах	Хүчтэй нууц үг шаардлага (8+ тэмдэгт, том, жижиг үсэг, тоо, тусгай тэмдэгт), хугацаатай шинэчлэлт, давхардах эсэхийг шалгах логик хөгжүүлэх.
3	Хэрэглэгчийн эрхийн удирдлага	Админ, энгийн хэрэглэгчийг ялгах, эрх олгох, идэвхгүй болгох, лог хянах боломж нэмэх.
4	Утас руу код илгээх API хөгжүүлэлт	Twilio болон Монгол операторын SMS API ашиглан OTP код илгээх горим нэвтрүүлэх.
5	Session control (Сессийн хяналт)	Нэг төхөөрөмжөөс нэвтэрсэн тохиолдолд өмнөх сессийг хүчингүй болгох, олон төхөөрөмжөөс зэрэг нэвтрэхийг хориглох.
6	Penetration test болон зөвлөмж	Системийн аюулгүй байдлын шалгалт хийж, эмзэг цэгүүдийг илрүүлэн сайжруулах зөвлөмж гаргах.
7	Хэрэглэгчийн сонголтын UI хөгжүүлэлт	Хэрэглэгч имэйл эсвэл утсаар OTP код авах сонголтыг хийх интерфэйс.
8	Имэйл нэвтрэлтийн SMTP тохиргоо	Gmail, Zoho гэх мэт SMTP сервертэй холбох тохиргоо хийх.
9	Deployment тест хийх	Хийгдсэн ажлаа хянах

Үнийн дүн: 10,000,000